

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хэмжлийн үнэн зөв байдлыг хангах, хэмжил зүйн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоож, хэмжил зүйн асуудлаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Хэмжил зүйн тухай хууль тогтоомж

2.1.Хэмжил зүйн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хэмжил зүйн үйл ажиллагаа, тогтолцоо, улсын болон иргэдийн эрх ашгийг хамгаалах, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд хэмжил зүйн дэд бүтцээр дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хууль үйлчилнэ.

##### 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хэмжил” гэж хэмжигдэхүүний тоон утгыг тодорхойлох үйл ажиллагааг;

4.1.2.“хэмжил зүй” гэж хэмжлийн тухай шинжлэх ухаан, түүний хэрэглээг;

4.1.3.“хэмжлийн нэгж” гэж хэмжил гүйцэтгэхэд жишиг болгон сонгож авсан нэгж хэмжигдэхүүнийг;

4.1.4.“хэмжлийн нэгж дамжуулалт” гэж хэмжлийн эргэлзээний тодорхой утга бүхий шалгалт тохируулгын албан ёсны шатлалаар дамжин эталоны утгатай уялдсан хэмжлийн үр дүнгийн шинж чанарыг;

4.1.5.“хэмжлийн эталон” гэж хэмжлийн нэгж, түүний тодорхой утгыг тогтоох, бий болгох, түүнийгээ хадгалах, хуулбарлах, харьцуулах замаар бусад хэмжих хэрэгсэлд дамжуулах зориулалттай хэмжих хэрэгслийг;

4.1.6.“шалгалт тохируулга” гэж тодорхой нөхцөлд хэмжлийн тогтоосон эргэлзээ бүхий эталоны утга, шалгагдаж байгаа хэмжих хэрэгслийн заалт хоорондын хамаарлаас хэмжлийн үр дүнг тогтоох үйл ажиллагааг;

4.1.7 “хэмжих хэрэгсэл” гэж хэмжил гүйцэтгэхэд ашиглаж байгаа хэмжил зүйн тогтоосон үзүүлэлт бүхий техник хэрэгслийг;

4.1.8.“хэмжил гүйцэтгэх аргачлал” гэж хэмжил гүйцэтгэх үндэслэл болгосон физикийн зарчим, тухайн хэмжих хэрэгслийг ашиглах нөхцөл, арга зүйг тогтоосон журмыг;

4.1.9.“хэмжил зүйн хяналт” гэж хэмжил зүйн салбар дахь төрийн хяналт, шалгалт, зохицуулалтын үйл ажиллагааг;

4.1.10.“загварын баталгаа” гэж хэмжих хэрэгслийн тодорхой загварт хийсэн туршилтын үр дүнг гэрчилгээгээр илэрхийлэх тохирлын үнэлгээний үйл ажиллагааг;

4.1.11.“хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт” гэж хэмжих хэрэгсэл нь тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг эрх бүхий байгууллагаас шалган нотолж, шалгалт баталгаажуулалтын тэмдгээр битүүмжлэн гэрчилгээ олгох тохирлын үнэлгээний үйл ажиллагааг;

4.1.12.“савласан бүтээгдэхүүн” гэж хэрэглэгчдэд зориулан тоон хэмжээг нь урьдчилан тогтоож, сав боодлыг задлах буюу эвдэхгүйгээр түүний доторхи бараа, бүтээгдэхүүний тоон хэмжээг өөрчлөх боломжгүйгээр савласан бүтээгдэхүүнийг;

4.1.13.“стандартчилсан загвар” гэж хэмжил хийхэд зориулалтын дагуу ашиглах, эсхүл хэвийн шинж чанарыг шалгах зорилгоор зохион бүтээсэн, жишиг болохуйц тусгай шинж чанартай, тогтвортой байдлыг нь тодорхойлсон, нэгэн төрлийн материалыг;

4.1.14.“хэмжил зүйн мэргэжлийн байгууллага” гэж хэмжил зүйн тодорхой үйл ажиллагааг эрхлэхээр эрх бүхий байгууллагаас итгэмжлэл авсан байгууллагыг;

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ХЭМЖИЛ ЗҮЙН ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

#### **5 дугаар зүйл. Хэмжил зүйн байгууллагын тогтолцоо**

5.1.Хэмжил зүйн байгууллагын тогтолцоо нь хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага болон хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаас бүрдэнэ.

## **6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

6.1.Төрийн захиргааны төв байгууллага хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.эрхэлсэн салбартаа хэмжил зүйн дэд бүтцийн бодлого, стратегийг тусгаж хэрэгжүүлэх, салбарын хэмжил зүйг хөгжүүлэх;

6.1.2.эрхэлсэн салбарын хэмжил зүйн техникийн зохицуулалтыг боловсруулж, Засгийн газраар батлуулах, мөрдүүлэх, хяналт тавих;

6.1.3.салбарын хэмжил зүйн ажлыг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн, мэргэшсэн байгууллагыг сонгох;

6.1.4.хэмжил зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд төлөөллөө оролцуулах.

## **7 дугаар зүйл. Хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага**

7.1.Төрөөс хэмжил зүйн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж, улсын хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг Засгийн газрын тохируулагч агентлаг -Хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

7.2.Хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

7.3.Хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.3.1.хэмжил зүйн дэд бүтцийн бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх;

7.3.2.хэмжлийн нэгжийн улсын болон анхдагч эталоныг бий болгох, хадгалах, ашиглах, хөгжүүлэх;

7.3.3. хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад эрх олгох;

7.3.4.улсын, анхдагч болон ажлын эталон, стандартчилсан загварыг зохион бүтээх, хэмжлийн нарийвчлалыг дээшлүүлэх асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх;

7.3.5.улсын болон анхдагч эталоны хөтлөлт, хэмжил гүйцэтгэх аргачлалыг боловсруулах, хэмжих хэрэгслийн загварыг турших, хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагад эрх олгох,

савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн шалгалт хийх зэрэг асуудлаар хэмжил зүйн дүрэм, журам боловсруулж батлуулах, мөрдүүлэх, биелэлтэд хяналт тавих;

7.3.6.эрхэлсэн асуудлаар олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, олон улс, бүс нутаг, гадаад улсын хэмжил зүйн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

7.3.7.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын захиалга, гэрээний дагуу төлбөрт ажил, үйлчилгээ, сургалт явуулах;

7.3.8.хэмжил зүйн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, ажиллуулах.

7.4.Хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дэргэдээ Хэмжил зүйн хүрээлэнтэй байж болно.

7.5.Хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хэмжил зүйн дэд бүтцийг хөгжүүлэх стратегийн бодлогоор санал боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус Хэмжил зүйн зөвлөлийг /цаашид “Зөвлөл” гэх/ төр, иргэн, аж ахуйн нэгж, шинжлэх ухааны болон бусад байгууллагын төлөөлөлтэйгээр байгуулж ажиллуулна.

7.6.Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **8 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллагын бүрэн эрх**

8.1.Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага нутаг дэвсгэртээ хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

8.2.Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллагын удирдлагыг Засаг даргатай зөвшилцөж, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

8.3.Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага нутаг дэвсгэртээ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.3.1.анхдагч болон ажлын эталоныг бий болгох, хадгалах, ашиглах, тэдгээрийн нэгж дамжуулалтыг хангах;

8.3.2.хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх;

8.3.3.хэмжил зүйн хяналт, савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд шалгалт хийх.

8.4.Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага нь итгэмжлэлийн хүрээнд хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын ажлыг гүйцэтгэж болно.

8.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэмжил зүйн дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

## **9 дүгээр зүйл. Хэмжил зүйн бусад байгууллага, иргэний эрх, үүрэг**

9.1.Аж ахуйн нэгж, байгууллага, түүний удирдлага нь эрхэлсэн ажил, үйлчилгээнийхээ хүрээнд хэмжил зүйн асуудлыг хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.хэмжил зүйн ажлыг тодорхой нэгж, албан тушаалтанд хариуцуулах, шаардлагатай бол хэмжил зүйн албыг байгуулан ажиллуулах;

9.1.2.хэмжлийн шаардагдах нарийвчлал, хязгаарт тохирсон хэмжих хэрэгслийг ашиглах, хэмжил зүйн дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

9.1.3.бүтээгдэхүүн борлуулалт, байгалийн нөөцийн олборлолт, ашиглалт, худалдаа, үйлчилгээний тооцоог зөвхөн баталгаатай хэмжих хэрэгслээр гүйцэтгэх;

9.1.4.хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт болон бусад ажил, үйлчилгээний холбогдох зардлыг бүрэн хариуцах;

9.1.5.Энэ хуулийн 20.2, 20.3-д заасан шаардлагыг хангасан савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд нийлүүлэгчийн мэдэгдэл гаргахаар бол хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх.

9.2.Энэ хуулийн 17.2, 18.2, 20.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж /хэмжил зүйн мэргэжлийн байгууллага/ нь хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх авсан байна.

9.3.Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

9.3.1.холбогдох хэмжлийн төрлөөр стандартчилсан загвар, анхдагч болон ажлын эталоныг бий болгох, хадгалах, хэмжих хэрэгслийн нэгж дамжуулалтыг хангах;

9.3.2.гүйцэтгэсэн хэмжлийн үр дүнгийн найдвартай, үнэн зөв байдлыг хариуцах.

9.4.Монгол Улсын иргэн өөрийн амьдрах орчин, эрхэлсэн ажил, үйлчилгээний хүрээнд дараах бүрэн эрхтэй:

9.4.1.өөрийн өмчлөлийн хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт, хэмжил зүйн хяналт шалгалт хийлгэх санал тавих;

9.4.2.хэмжил зүйн ажил, үйлчилгээ, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалтын талаар иж бүрэн мэдээллийг авах;

9.4.3.хэмжих хэрэгслийн ашиглалт, хэмжил гүйцэтгэх аргачлал, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын явцад гарсан зөрчлийн холбогдолтой мэдээлэл өгөх;

9.4.4.өөрийн эзэмшлийн хэмжих хэрэгслийн загварын туршилт, шалгалт баталгаажуулалтын үйл ажиллагаанд ажиглагчаар оролцох, энэ талаар санал, хүсэлтээ гаргах.

9.5.Төрийн бус байгууллага нь хэмжил зүйн талаар дараах бүрэн эрхтэй:

9.5.1.энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад оролцох;

9.5.2.хэмжил зүйн хууль тогтоомжийн зөрчлийн тухай холбогдох байгууллагад мэдээлэх, зөрчлийг таслан зогсоох, зөрчлийн шалтгааныг арилгахыг холбогдох албан тушаалтнаас шаардах;

9.5.3.хэмжил зүйн бодлого, хууль тогтоомжийг боловсруулахад саналаа танилцуулах.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **ХЭМЖИЛ ЗҮЙН ДЭД БҮТЭЦ, БОДЛОГО, СТРАТЕГИ**

#### **10 дугаар зүйл. Хэмжил зүйн дэд бүтэц**

10.1.Монгол Улсын хэмжил зүйн дэд бүтэц нь эдийн засаг, нийгмийн дэд бүтцийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

10.2.Хэмжил зүйн дэд бүтэц нь шинжлэх ухаан, техник, зохион байгуулалт болон хууль эрх зүйн доор дурдсан бүрэлдэхүүнтэй байна:

10.2.1.зохион байгуулалтын бүрэлдэхүүн нь хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хэмжил зүйн зөвлөл, хэмжил зүйн байгууллага болон бусад байгууллага;

10.2.2.техникийн бүрэлдэхүүн нь хэмжлийн нэгж, эталоны тогтолцоо, нэгж дамжуулалт, ажлын хэмжих хэрэгсэл, стандартчилсан загвар, хэмжил зүйн ажил, үйлчилгээ;

10.2.3.шинжлэх ухааны бүрэлдэхүүн нь хэмжил зүйн мэдлэг, боловсрол олгох болон мэргэшүүлэх сургалтын тогтолцоо, хэмжил зүйн олон улс, бүс нутгийн байгууллагын хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээ, судалгааны ажил;

10.2.4.хууль эрх зүйн бүрэлдэхүүн нь хэмжил зүйн хууль тогтоомж болон хэмжил зүйн зохицуулалт, стандарт бүхий баримт бичиг.

#### **11 дүгээр зүйл. Хэмжил зүйн бодлого, стратеги**

11.1.Монгол Улс нь нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, байгаль орчин, эрүүл мэнд, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, шударга худалдааг дэмжих, худалдаан дахь техникийн саад, тотгорыг арилгахад чиглэсэн хэмжил зүйн дэд бүтцийн бодлого, стратегитэй байна.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан бодлого, стратегийг Засгийн газар батална.

11.3.Хэмжил зүйн бодлого, стратегийг үндэслэн хэмжил зүйг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ХЭМЖЛИЙН НЭГЖ, ХЭМЖЛИЙН НЭГЖИЙН ЭТАЛОН, НЭГЖ ДАМЖУУЛАЛТ**

#### **12 дугаар зүйл. Хэмжлийн нэгж**

12.1.Монгол Улсад хэрэглэх хэмжлийн нэгж нь Жин, хэмжүүрийн ерөнхий бага хурлаас тогтоосон Хэмжлийн нэгжийн олон улсын систем (SI)-ийн нэгж байна.

12.2.Энэ хуулийн 12.1-д зааснаас бусад хэмжлийн нэгжийг Засгийн газрын шийдвэрээр Хэмжлийн нэгжийн олон улсын системийн нэгжтэй нэг адил хэрэглэж болно.

12.3.Хэмжлийн нэгжийн нэр, тэмдэглэгээ болон тэдгээрийг бичих, хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

12.4.Экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүний чанар, техникийн үзүүлэлтийг захиалагчаас хүссэн хэмжлийн нэгжээр илэрхийлж болно.

#### **13 дугаар зүйл. Хэмжлийн нэгжийн эталон, стандартчилсан загвар**

13.1.Хэмжлийн нэгжийн улсын болон анхдагч эталоныг хэмжил зүйн дэд бүтцийн бодлого, стратегийн дагуу бий болгоно.

13.2.Хэмжлийн нэгжийн улсын эталоныг Засгийн газар, анхдагч эталоныг хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

13.3.Улсын болон анхдагч эталон нь төрийн өмч бөгөөд төрийн хамгаалалтад байна.

13.4.Стандартчилсан загварыг бодис болон материалын бүтэц, шинж чанарын нэгжээр илэрхийлсэн үзүүлэлтийг хуулбарлан гаргах, хадгалах, дамжуулахад хэрэглэнэ.

13.5.Улсын болон анхдагч эталон, хэмжил зүйн үйл ажиллагаанд ашиглах стандартчилсан загварыг Хэмжил зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

#### **14 дүгээр зүйл. Нэгж дамжуулалт**

14.1.Улсын болон анхдагч эталон, стандартчилсан загвар нь Хэмжлийн нэгжийн олон улсын системтэй уялдсан байна.

14.2.Улсын болон анхдагч эталон, стандартчилсан загварын нэгж дамжуулалтыг хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эсхүл түүнээс эрх олгосон хэмжил зүйн мэргэжлийн байгууллага олон улсын эсхүл бусад орны хүлээн зөвшөөрсөн холбогдох эталонтой харьцуулах замаар хангана.

14.3.Хэмжлийн нэгжийг улсын эсхүл анхдагч эталоноос баталсан аргачлалын дагуу холбогдох хэмжих хэрэгсэлд дамжуулна. Ажлын хэмжих хэрэгсэлд дээд шатны эталоноос нэгж дамжуулалт хийгдсэн байна.

#### **15 дугаар зүйл. Хэмжил, хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлал**

15.1.Хэмжих хэрэгсэл нь баталсан загвар, улсын стандарт, техникийн болон ашиглалтын шаардлагыг хангасан байна.

15.2.Хэмжил зүйн хяналтад хамруулах хэмжил, хэмжих хэрэгслийн жагсаалтыг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.3.Хэмжил зүйн хяналтын үйл ажиллагаанд загвар нь батлагдсан, шалгалт баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийг ашиглана.

15.4.Хэмжил зүйн хяналтын үйл ажиллагаанд ашиглах хэмжих хэрэгсэл нь хэмжлийн үр дүнд нөлөөлөхөөс сэргийлсэн хийц, битүүмжлэлтэй байна.

15.5.Хэмжлийг хүчин төгөлдөр улсын стандарт, аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

### **ТАВДУГААР БҮЛЭГ**

#### **ХЭМЖИЛ ЗҮЙН ХЯНАЛТ**

#### **16 дугаар зүйл. Хэмжил зүйн хяналт, түүний хүрээ, хэлбэр**

16.1.Дараах үйл ажиллагаанд ашиглах хэмжил, хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлалыг хэмжил зүйн хяналтад хамруулна:

16.1.1.худалдаа, үйлчилгээний тооцоо;

16.1.2.хүн, мал эмнэлгийн оношлогоо, эмчилгээ;

16.1.3.байгаль орчны хамгаалал;

16.1.4.улсыг батлан хамгаалах;

16.1.5.аюулгүй байдлыг хангах.



16.2.Хэмжил зүйн хяналтыг дараах хэлбэрээр гүйцэтгэнэ:

16.2.1.хэмжих хэрэгслийн загварыг турших;

16.2.2.хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулах;

16.2.3.хэмжих хэрэгслийг импортоор нийлүүлэх, суурилуулах, засварлах аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх;

16.2.4.савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд шалгалт хийх;

16.2.5.хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих.

16.3.Хэмжил зүйн хяналтыг улсын хэмжээнд хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага тус тус хэрэгжүүлнэ.

## **17 дугаар зүйл. Хэмжих хэрэгслийн загварын туршилт**

17.1.Энэ хуулийн 16.1.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийн загварын туршилтыг хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

17.2.Энэ хуулийн 16.1.2-16.1.5-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийн загварын туршилтыг хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон хэмжил зүйн мэргэжлийн болон итгэмжлэгдсэн байгууллага гүйцэтгэж болно.

17.3.Энэ хуулийн 16.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг импортоор нийлүүлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн хэмжих хэрэгслийн загварын туршилтын үр дүнгийн тайлан, загварын гэрчилгээ, норматив-техникийн болон ашиглалтын баримт бичгийн хамт загварын туршилт хийх байгууллагад ирүүлнэ.

17.4.Хэмжих хэрэгслийн загварыг хэмжил зүйн олон улсын байгууллагын зөвлөмжид нийцсэн олон улс болон үндэсний стандарт, баталсан аргачлалын дагуу өөрийн орны байгаль, цаг агаарын нөхцөлд хэрхэн нийцэх талаар зарим үзүүлэлтийг сонгон туршина.

17.5.Хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага загварын туршилтад тэнцсэн болон загварын туршилтын үр дүнг нь хүлээн зөвшөөрсөн хэмжих хэрэгслийн загварыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоно.

17.6.Импортоор нийлүүлэх хэмжих хэрэгсэл нь хэмжил зүйн олон улсын байгууллага болон түүнээс загварын гэрчилгээ олгох эрх бүхий үйлдвэрлэгчийн хүчин төгөлдөр загварын туршилтын гэрчилгээтэй бол загварын туршилтыг хийхгүйгээр түүнийг хүлээн зөвшөөрч болно.

17.7.Үйлдвэрлэгч орны хэмжил зүйн байгууллагаас олгосон загварын

туршилтын үр дүнг дотоодын хэмжил зүйн эрх бүхий байгууллага хооронд байгуулсан хэлэлцээрийн үндсэн дээр харилцан хүлээн зөвшөөрч болно.

## **18 дугаар зүйл. Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт**

18.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 16.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг импортоор нийлүүлсэн, үйлдвэрлэл, суурилуулалт, засвараас гарсны дараа, мөн тэдгээрийг ашиглах, хадгалах явцад шалгалт баталгаажуулалтад заавал хамруулна.

18.2.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлыг аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага эрхэлнэ. Хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон хэмжил зүйн мэргэжлийн байгууллага итгэмжлэгдсэний үндсэн дээр энэ хуулийн 16.1.2-16.1.5-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг гүйцэтгэнэ.

18.3.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын ажлыг хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэмжүүрийн улсын шалгагчийн эрх авсан ажилтан нэгж дамжуулсан эталон ашиглан хүчин төгөлдөр стандарт, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

18.4.Шалгалт баталгаажуулалтад тэнцсэн хэмжих хэрэгслийг батлагдсан загварын лац, тэмдгээр битүүмжилж, гэрчилгээ олгоно.

18.5.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын лац, тэмдэг, гэрчилгээ, мэдэгдлийн загварыг хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

18.6.Баталгаажуулалтын лац, тэмдэг нь хөндөгдсөн буюу арилсан, гэрчилгээг үрэгдүүлсэн, хуурамчаар үйлдсэн, шалгалт баталгаажуулалтын хугацаа нь дууссан, эсхүл эвдэрсэн буюу буруу заалттай хэмжих хэрэгслийг баталгаагүйд тооцно.

18.7.Баталгаагүй хэмжих хэрэгслийг худалдах, ашиглахыг хориглоно.

18.8.Загварын туршилтад хамрагдаагүй хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад хамруулахгүй.

18.9.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт хоорондын хугацааг хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

18.10.Хэмжил зүйн олон улсын байгууллагаас эрх авсан, эсхүл олон улсын итгэмжлэлийн тогтолцооны дагуу итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчийн хэмжих хэрэгслийн анхдагч шалгалт баталгаажуулалтын үр дүнг гэрээний үндсэн дээр харилцан хүлээн зөвшөөрч болно.

## **19 дүгээр зүйл. Хэмжих хэрэгслийг импортоор нийлүүлэх, суурилуулах, засварлах аж ахуйн нэгж, байгууллага**

19.1.Энэ хуулийн 16.1.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг

импортоор нийлүүлэх, суурилуулах, засварлах аж ахуйн нэгж, байгууллагыг хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэнэ.

## **20 дугаар зүйл. Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний шалгалт**

20.1.Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний шалгалтыг хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага, итгэмжлэгдсэн шалгалтын байгууллага хэрэгжүүлнэ.

20.2.Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний дундаж утга нь стандарт, сав, боодол дээрх, эсхүл дагалдах баримт бичигт тэмдэглэсэн тоон хэмжээний хэвийн утгатай, эсхүл тодорхой нэг савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний утга нь хэвийн утгын зөвшөөрөгдөх хэлбэлзлийн хязгаартай тус тус тохирч байна.

20.3.Савласан бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго нь улсын стандартын шаардлагыг хангасан байна.

## **21 дүгээр зүйл. Хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт**

21.1.Хэмжил зүйн хяналт шалгалтыг хэмжил зүйн улсын байцаагч хэрэгжүүлнэ.

21.2.Хэмжил зүйн улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг эрх, үүргээс гадна хэмжил зүйн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.2.1.хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт, хэмжил гүйцэтгэх аргачлалын мөрдөлтөд хяналт тавих;

21.2.2.баталгаагүй, эсхүл загвар нь баталгаагүй буюу баталсан загвартаа тохирохгүй байгаа хэмжих хэрэгсэл ашиглах, суурилуулах, импортоор нийлүүлэхийг хориглох;

21.2.3.хэмжлийн нэгж нь хэрэглэхийг зөвшөөрсөн нэгжтэй тохирч байгаад хяналт тавих;

21.2.4.хэмжих хэрэгслийг импортоор нийлүүлэх, суурилуулах, засварлах үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бол бүртгэлийг хүчингүй болгохыг шаардах;

21.2.5.хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, ашиглалт, хэвийн ажиллагаанд хяналт тавих, баталгаажуулалтын хугацаа дууссан буюу буруу заалттай хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын тэмдэг, гэрчилгээг хүчингүй болгох, хураах;

21.2.6.савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний шалгалтын явцад хяналт тавих;

21.2.7.хэмжил зүйн хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай

хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

21.2.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **22 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хэмжил зүйн дотоод хяналт**

22.1.Аж ахуйн нэгж, байгууллага, түүний хэмжил зүйн алба нь хэмжил зүйн дотоод хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

22.1.1.хэмжих хэрэгслийг загварын туршилт, шалгалт баталгаажуулалтад хугацаанд нь бүрэн хамруулж байгаа эсэхэд хяналт тавих;

22.1.2.технологийн хяналтын хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгад хамруулах;

22.1.3.хэмжих хэрэгслийн техникийн бэлэн байдал, ашиглалтад болон хэмжил гүйцэтгэх аргачлал, хэмжлийн шаардагдах нарийвчлал, хэмжил зүйн хууль тогтоомжийн мөрдөлтөд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах.

## **23 дугаар зүйл. Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга**

23.1.Энэ хуулийн 16.1.-д заасан үйл ажиллагаанд хэрэглэхээс бусад хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгад хамруулж болно.

23.2.Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын лаборатори нь итгэмжлэгдсэн байна.

23.3.Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгыг нэгж дамжуулсан эталон ашиглан гүйцэтгэнэ.

23.4 Шалгалт тохируулга хийсэн хэмжих хэрэгсэлд гэрчилгээ олгож, тэмдэг дарна.

23.5.Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх талаар Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан хоёр болон олон талт гэрээ, хэлэлцээрийн хүрээнд шалгалт тохируулгын гэрчилгээг хүлээн зөвшөөрнө болно.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ**

### **БУСАД ЗҮЙЛ**

## **24 дүгээр зүйл. Хэмжил зүйн үйл ажиллагааны санхүүжилт**

24.1.Хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллагаас энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

24.2.Хэмжил зүйн олон улсын байгууллагын гишүүний татварыг улсын төсвийн

орлогоос санхүүжүүлнэ.

24.3.Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

### **25 дугаар зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

25.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **26 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

26.1.Энэ хуулийг 2016 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг